

“Монголын довтолгооны хуйлмал бичиг” (蒙古襲来絵詞 Moko Shurai Ekotoba) дэх монголчуудын дүрслэлийн тухай ажиглалт

Уламбаярын Эрдэнэбат^{1,*}

Товч агуулга: “Монголын довтолгооны хуйлмал бичиг” нь 13 дугаар зууны сүүл үеийн Юань, Япон цэргүүдийн дүр төрх, хувцас өмсгөл, хэрэглэж байсан зэр эвсэг, агт морины тоног хэрэгсэл, хөлөг онгоцны төрх байдал, байлдааны арга барил, цэргийн ухаан зэргийг судлахад чухал ач холбогдолтой эх сурвалж юм. Энэ өгүүлэлд тус зургийн сурвалжид буй Монголчуудын дүрслэлийн тухай ажиглалт хийсэн зарим үр дүнгээс хуваалцаж байна.

Түлхүүр үг: Монголын эзэнт гүрэн, Юань улс, Хубилай хаан, Монголчууд Япон улсад довтолсон нь, Монголын довтолгооны хуйлмал бичиг

Удиртгал

Монголын их хаан Хубилайн үед Юань улс 1274, 1281 онуудад Японы эсрэг хоёр удаа халдан довтолжээ. Японы ард түмэн эх орноо баатарлагаар хамгаалж, Юань улсын флот далайн хар шуурганд өртөж сүйрсэн байдаг. Японы археологичид 1980-аад оноос далайн гүнд эрчимтэй судалгаа хийж Хаката булангийн дэргэдэх Такашима арлын орчим монгол флотын үлдэгдлийг олж малтлагаас гарсан сонирхолтой олдворуудаас бүрдсэн тусгай музей байгуулжээ.

Миний бие 2010 оны 10 дугаар сард энэхүү музейтэй анх удаа танилцах завшаан олдсон бөгөөд энэ тухайгаа 2012 онд хэвлүүлсэн “Археологийн үндэс- Судалгааны аргазүй” сурах бичигтээ “Усан доорхи археологи” хэмээх сэдэвт оруулж товч бичсэн юм (Эрдэнэбат 2012: 131-135). 2024 оны 3 дугаар сард Кюүшү, Такашима, Икишима арлуудаар зочилж, 750 жилийн өмнөх үйл явдлын мөрийг хадгалсан түүхэн дурсгалт газруудаар япон, монгол нөхдийн хамт аялсандаа баяртай байна.

Япон улсад Юань гүрний довтолгоонтой холбоотой цөөнгүй дурсгал байдгаас “Монголын довтолгооны хуйлмал бичиг” (蒙古襲来絵詞 Moko Shurai Ekotoba) хэмээх зурагт ном түүх болон урлагийн хувьд чухал ач холбогдолтой, тухайн цаг үеийн ховор эх сурвалж болно. Энэхүү бүтээлийн гол дүр Такезаки Суенага бол Кюүшү арлын Хюго мужийн харъяат хүн. 13 дугаар зууны Камакурагийн үеийн самурай бөгөөд монголчуудын эсрэг дээрх хоёр удаагийн тулалдаанд

биечлэн оролцсон, энэхүү дайнд байгуулсан гавъяа, баатарлаг үйлсээ харуулах зорилгоор уг хуйлмал номыг захиалж бүтээлгэсэн гэдэг (Conlan 2001).

“Монголын довтолгооны хуйлмал бичиг” гэдэг хоёр хөндлөн хуйлмал (takimono) нь Японы хамгийн алдартай макимоногийн тоонд ордог. Нэг дэх хуйлмал нь 23 метр гаруй, нөгөө нь ойролцоогоор 20 метр урт, өргөн нь 39.5 см. Хуйлмал бүртээ 40 гаруй зурагтай, зургийн хэсгүүдийг япон хэлээр бичсэн товч тайлбар бичвэрээр таслан хуваасан байдаг ажээ (Мөнхцэцэг 2015a: 100-115).

Хуйлмал зургуудад Японы зоригт баатруудын нэг Такезаки Суенагагийн баатарлаг үйлсийг илүүтэй алдаршуулдаг. Монголчууд Японд довтолсон сүүлчийн тулалдаанаас хойш 12 жилийн дараа буюу 1293 онд Такезаки өөрийн үзэж туулсан зүйлсээ бичиж, зурган дээр буулгах даалгавар өгсөн байна. Бичвэрийн зохиогч ба зураачийн нэр тодорхой бус. Уг нь гурван хуйлмал байх ёстой байсан. Тэднийг одоогийн байдлаар нь Монголчуудын эсрэг тулалдаанд онцгойрсон дайчин эрийн удмынхан 1890 онд Мэйжи хаанд бэлэглэсэн ажээ. Энэхүү хуйлмал бичгийн хэд хэдэн хувилбар буюу 13 дугаар зууны сүүлээр зохиосон эх бичиг, 18 дугаар зууны үед үйлдсэн хуулбар, Фукуда Тайкагийн гараар зурж хувилсан 19 дүгээр зууны үеийн хувилбар, 21 дүгээр зуунд сэргээн засч хуулбарласан хувилбарууд хадгалагдаж үлдсэн. Анхны эх хувилбар нь эзэн хааны гэр бүлийн өмч бөгөөд Токиогийн хааны ордон дахь эзэн хааны цуглуулгын музейд хадгалдаг байна.

¹ МУИС, Шинжлэх Ухааны Сургууль, Антропологи, Археологийн тэнхим, Нүүдэлчдийн археологийн хүрээлэн

* Холбоо барих зохиогч: u_erdenebat@num.edu.mn
<https://orcid.org/0000-0003-0867-3691>

Хөндлөн хуйлмал бичгийн товч агуулга нь:

Нэгдүгээр хуйлмал: Монголын анхны довтолгоо (1274 он)

Энд тулаан арлын хуурай газар болдог. Японы дайчид, тугчингууд сүмийн төгөл дундуур яаран давхиж байна. Дараа нь тэд мориноосоо бууж, зөвлөлдөж байгаад дахин урагшилна. Нэг морь сульдана унаж байна, унасан хүн нь, гартаа тугаа барьсаар явганаар урагшилна (Зураг 1).

Юаний цэргүүд хувцасныхаа хувьд япончуудаас эрс ялгаатай, тэд урт хормойтой, эсгий гадартай ширээстэй дээл, өндөр түрийтэй арьсан гутал өмсөж, хүзүүгээ битүү халхалсан юүдэн шиг шилэвчтэй дуулга малгай өмссөн, царай зүс нь харгис хэрцгий, суманд хөөгдөн зугтана. Шуурганд цохиулсан нарсны доор суманд оногдож, олон шархнаас нь цус урссан Сүенагагийн морь доошоо унана. Гэвч баатар жолоогоо чанга атгасан хэвээр. Түүний дээгүүр галт бөмбөлгүүд тэсэрч, сум, жад шунгинан ирнэ. Монголчууд түүн рүү харваж байна (Зураг 2). Монголчууд бас морь унаж ирсэн ажээ. Морьтон дайчдын хүчирхэг

хэнгэрэг, бөмбөр, харанга нь дайчид болон морьдыг тулалдаанд урамшуулна (Зураг 3). Урт бичвэр. Дараа нь Японы ордон. Ордны ноёд сайхан өрөөнд тайван, ядарсан сууж байна. Ялагч болон түүний хамтрагч амьсгаадсан морьдоос яаран бууж, одоо Сүенага эзэн хааны хамгийн нөлөө бүхий түшмэл Акитажоносукэ Ясуморид илтгэж байна. Эцэст нь Сүенагад эзэн хаанаас бэлэг болгон, алагдсан дайны морины нь оронд галт азарга бэлэглэв (Зураг 4).

Хоёрдугаар хуйлмал: Монголын хоёр дахь довтолгоо (1281 он)

Энд тулаан далайд болдог.

Элч дайсны флот гарч ирсэн тухай мэдээ авчирна (Зураг 5). Арзайсан нарс мододын өмнө босгосон чулуун хэрмийн ханан дээгүүр шүдээ хүртэл зэвсэглэсэн япон дайчид дүүрэн сумтай саадгаа агсан сууна. Тэд гадагш харна. Жад, туг, далбаа баригчид явганаар, морь унасан дайчид бүгд асар их догдолж, довтлоход бэлэн байна (Зураг 6). Өгүүллийн хүүрнэл текст нь дараагийн зурагт бэлтгэнэ.


Хөндлөн суудалт үүлсээр хөшиглөсөн нарс модод



Зураг 1.



Зураг 2.



Зураг 3.



Зураг 4.

нь далайн эргийг харуулж байгаа юм. Жижиг хавтгай завин дээр суусан дайчид хажуу талд нь бамбайгаа өлгөж, гартаа нумаа барин сууна (Зураг 7). Дахин нэг текст үг хэлнэ. Дараа нь өндөр жолооны хүртэй монголчуудын гоёмсог, баян хөлөг онгоц. Японы дайчид жижиг завиараа хөлөг онгоц руу дайрч, багийнхныг устгадаг. Сүенагад цавчуулсан нэг хүн хөлгөөс цусанд хутгалдан живж, эргэн тойронд нь өндөр давалгаа үүснэ. Сумнууд агаарт эргэлдэнэ (Зураг 8).


Монгол дайчид битүү суусан олон хүнтэй хөлөг онгоц эр зоригтойгоор өөрийгөө хамгаалдаг (Зураг 9). Тэмцэгчид Буддын шашны свастика буюу хас тэмдэг бүхий бамбайгаа хажуу жигүүрийн дагуу байрлуулж, зай завсаргүй харвах сумнаас хамгаалсан байна (Зураг 10).

Цаашдын бичвэрийн дагуу сүмийн хаалга, дээвэр манангаас цухуйсан байна. Японы дайчид далай

дээгүүр харж байна (Зураг 11). Сүенага болон түүний зарим дагалдагсад ёслолын хувцастай төгөлд сууна. Тэдний өмнө унасан дайснуудын толгой байх (Зураг 12) бөгөөд тэдгээр нь бурхдыг тахилах зориулжээ (Fischer-Wieruszowski 1935: 121-124).

Хэлэлцүүлэг

“Монголын довтолгооны хуйлмал бичиг” нь Юань, Япон цэргүүдийн дүр төрх, хувцас өмсгөл, хэрэглэж байсан зэр ээвсэг, агт морины тоног хэрэгсэл, хөлөг онгоцны төрх байдал, байлдааны арга барил, цэргийн ухаан зэргийг судлахад чухал ач холбогдолтой эх сурвалж юм. Эдгээр зурагт сэтгэл хөдөлгөм үйл явдлуудыг гайхалтай хүчтэй дүрсэлсэн байдаг. Урагшаа ухасхийж, эргэж ухарч байгаа, булгиж цоройж буй морио жолооноос нь чанга атгасан дайчид, далайд гарч буй сэлүүрчдийн эрч хүч, хүсэл



Зураг 5.



Зураг 6.

эрмэлзэл, дайснаа хүлээн ширтэж байгаа цэргүүдийн байр байдлыг гайхалтай амьдлаг дүрсэлжээ. Бид тус зургийн сурвалжид буй Монголчуудын дүрслэлийн тухай ажиглалт хийсэн зарим үр дүнгээс товчлон та бүхэнтэй хуваалцаж байна.

Хувцас өмсгөл. Мэдээж хэрэг дайн тулааны үе тул зурагт дүрслэгдсэн хүмүүсийн ихэнх нь хамгаалалтын хуяг дуулга өмсжээ. Юаний цэргүүдийн хувьд япончуудынхаас ялгаатай нь, ихэнх цэргүүд “хатангу дээл” буюу хуяглаж хатуу болгосон дээл өмссөн ажээ (Зураг 13). Энэ бол эртний монголчуудын хэрэглэж асан өвөрмөц нэгэн хуяг бөгөөд аливаа дайн байлдаанд оролцогч хүн гагц гарт барих зэвсгээ ч бус, бас хувцас хунараа тохируулан зэхдэг байжээ. Тэгэхдээ юуны урьд өөрсдийн өдөр тутам өмсөж дадсан үндэсний хувцсаа харвах сум, цавчих илдний ир үл нэвтрэхээр болгох аргыг сүвэгчилдэг байв. Монголчуудын хувьд уламжлалт гол хувцас нь дээл учир эрт балрын үеэс дайн байлдаанд эн түрүүнд дээлээ хуяглан өмсдөг байжээ. Ийм хуягийн монголчууд бас “дэгэлэй хуяг” гэж нэрлэдэг байсан бөгөөд эсгий, олс мяндас давхарлан ширж оёсон нэгэн зүйлийн зөөлөн хуяг байв. Монгол цэргүүд үүнийг дангаар нь юмуу эсвэл төмөрлөг хуягтай давхарлан өмсөж байжээ.

Монгол Улсын Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Шүүт (Зураг 15), Баянцагаан сумын нутаг Дугуй Цахирын хадны оршуулгаас эртний монгол цэргийн эсгий дээл, мөн хоолой давсан өндөр захтай,

дээр нь эсгий давхарлаж зузаалж оёсон нэхий дээлийн үлдэгдэл (Зураг 14, 16) олдсон байдаг (Эрдэнэбат, Амартүвшин 2010; Эрдэнэбат 2014). Иймэрхүү зөөлөн дэгэлэй хуяг 13-14 дүгээр зууны үед өөрийн уян хатан чанар ба хийхэд амар, өртөг багатай байдлаас болж Зүүн хойд Азийн нүүдэлчид, түүний дотор ялангуяа монголчуудын дунд маш их дэлгэрсэн байжээ (Зураг 17).

“Монголын довтолгооны хуйлмал бичгийн” зургийн дотор, биедээ ширмэл хуяг, мөн арьс ширэн тушим хэлхсэн өвч хуяг дуулгатай цэргүүд харагдаж байна (Зураг 18). Тусгай аргаар боловсруулж, төмөрлөг болон хэр баргийн сум нэвтрэхээргүй болгож хатууруулсан арьс ширэн хуягийг хөө хуяг, ялтсан хуяг зэрэг төмөрлөгөөр үйлдсэн хатуу хуягийн зэрэгцээ өргөн хэрэглэж байлаа. 13 дугаар зууны үед Монголд ирсэн жуулчны тэмдэглэлд: “... арьс ширээр хуяглана. Хуягийг дараах маягаар үйлдэнэ: Бух буюу бусад амьтны алга дарам өргөн шир аван гурав, дөрвөөр нь тавьж давирхайдаад хооронд нь нарийн сур буюу олсоор үдэн торгооно. Тэгээд дээд талын ширнийхээ доод ирмэгийг дараагийн ширний дунд хэсэгтэй нь сураар хэлхэх маягаар хуяг хийх бөгөөд ингэж хийсэн хуягийг өмсөхөд хэлхээтэй ширний доод талынх нь дээд талынхаа доогуур нь шурган орж хоёр буюу гурван давхар болох бөлгөө” гэх зэргээр бичсэн байдаг (Плано Карпини 1988: 39).

Юаний цэргүүдийн өмссөн дуулга нь ерөнхийдөө

гурван янз байгаа бололтой харагдана (Зураг 18-22). Нэг нь намхан оройтой хоёр шанааны талдаа жигүүр маягийн зүйлтэй. Шилэн хүзүү, хоолой, дал мөрийг битүү хамгаалсан хамгаалалттай. Хоёр дахь нь бөмбөгөр оройтой, алтан шаргал өнгийн чимэглэлтэй, хоёр шанаа талдаа жигүүр маягийн зүйлтэй, тэр нь эхний хэлбэрийн дуулгатай харьцуулахад илүү том. Дух магнайн хэсэгтээ саравч маягийн урагшаа гарсан хамгаалалттай. Гурав дахь хэлбэрийн дуулга нь шовгор оройтой, улаан хүрэн өнгөтэй, хүний зөвхөн нүд, хамар, ам ил гарч дух, эрүү, хүзүү хэсгийг битүү хамгаалсан аж. Иймэрхүү хэлбэрийн шовгор оройтой төмөр дуулга Такашима арал орчим хийсэн усан доорх археологийн судалгаагаар биет байдлаар олдсон байдаг. Харин дээшээ илүү гарсан саравчтай, хоёр шанаандаа жигүүр мэт зүйлтэй дуулга монголчуудын ширэн дуулганы нэгэн хэлбэрийг санагдуулах агаад Эдинбургийн цуглуулгад буй Рашид-ад-дины “Судрын чуулганы” миниатюр зурагт дүрсэлсэн ба ОХУ-ын Марджани сангийн цуглуулганд хадгалагдаж байгаа 14 дүгээр зууны монгол цэргийн ширэн дуулгатай (Зураг 23) харьцуулж болох юм (Дружинина 2018: 110-112).

Зэр зэвсэг. Монгол нутаг дахь эрт дундад үеийн бүхий л нүүдэлчдийн байлдааны зэр зэвсэг ба ангийн хэрэгслийн хамгийн чухал төрөл бол юуны өмнө нум сум байсан билээ. Монголчууд ба тэдний өвөг дээдэс олон төрлийн зэвсэг хэрэглэж байсны дотроос хамгийн хүчтэй нь зүймэл нум болох бөгөөд нүүдэлчдийн булш оршуулгаас гагц энэ төрлийн нумын үлдэгдэл олдож байдаг. Нумын энэ төрөлд их биеийн үүсгэрийн модон дээр эвэр, ясаар хийсэн наалтуудыг мал амьтны шөрмөс орхин бэхлэж зүйж хийсэн бүх нум багтах бөгөөд илүү хүчтэй, хол харвадаг ажээ.

Монголчуудын довтолгооны тухай тэр үеийн Япон сурвалжид: “Юань улсын цэрэг гайхалтай эрчтэй нум сумтай. Хорт сум, дарь зэрэг нь Японы цэрэгт байхгүй шинэ зэвсэг хэрэглэж, цан, бөмбөрийн дохиогоор бөөнөөр давшин байлдаж байв”. “Япончуудын нум сум урт, дайсны хориглолтонд сум нь хүрэхгүй байхад, монголчуудын нум сум богино атал бидний талд элбэг тусч байлаа. Дэлбэрдэг “буу” нь хохирол

учруулахаасаа, тулалдааны тэргүүн шугамыг замбараагүй болгоход илүү нөлөөтэй байв”, “... дайсны сум үзүүртээ хортой, шарх авахад, бүх биеэр хор нэвчиж, өмхийрч амь насаа алддаг. Манайхан их хохирол үзэж, яваандаа ялагдах шинжтэй болж ирэв” гэх зэргээр тэмдэглэж байжээ (Мөнхцэцэг 2015b: 138).

Нум сумын дараа орох түгээмэл зэвсэг нь илд байв. Түүнээс гадна урт иштэй жад хэрэглэж байсныг “Монголын довтолгооны хуйлмал бичиг”-т тодорхой дүрсэлжээ (Зураг 13). Дундад эртний монголчууд дугуй, зууван, гонзгой дөрвөлжин том жижиг бамбай хэрэглэж байжээ. Бамбайг хийхдээ уян хатан, бөх бат модны мөчрөөр сүлжин олон өнгийн утсаар хээ хуар гарган чимэглэнэ. Бас түүнийг хатуу ширээр гадарлан төмрөөр тасамдан эмжиж, дунд нь толь хадсан байх нь олонтаа. Япон зурагт дүрсэлсэн гонзгой дөрвөлжин хэлбэртэй том бамбайг монголчууд “тулас” хэмээн нэрлэдэг бөгөөд хот цайзыг дайлах, дайсныг өдөөж хөдөлгөх, бүслэн хаахад хэрэглэдэг байв. Энэ зурагт Юаний цэргийн бамбайн дээр Буддын шашны свастика буюу хас тэмдэг, мөн одоо хүртэл Монголчуудын малын тамганд байдаг “ёнгоруун” тамга дүрсэлсэн нь сонирхолтой (Зураг 21).

13 дугаар зууны монголчууд нум сумаа агуулах олон төрлийн сав хэрэглэж явсныг Монгол улсын нутгаас илрүүлэн олсон археологийн олдворууд гэрчилнэ. Иймээс саадаг, хоромсогоны төрөл анги тус бүрийг ялган нэрлэх тусгай нэр томъёо маш их хөгжсөн байна. Япон зурагт дүрсэлсэн Юаний цэргүүд гонзгой хэлбэртэй, харвуулын сумыг агуулахдаа зэвтэй талыг нь саван дотроо, өдтэй талыг нь гадагш савны амнаас цухуйж байхаар хийсэн саадаг голдуу хэрэглэж байна. Монголчууд саадгийг ихэвчлэн хусны үйс, бас мал амьтны арьс ширээр хийж байсан бөгөөд заримдаа ургамал амьтан, геометрийн дүрс зэрэг гоёмсог хээ угалзтай ясан болон төмөрлөг чимэглэлээр гоёдог байв. “Монголын довтолгооны хуйлмал бичгийн” зургийн дотор, луугийн дүрсээр чимэглэсэн, ирвэсний арьсаар хийсэн саадагтай дайчдыг дүрслэн үзүүлсэн нь тэр үеийн монголчуудын саадагны байдалтай нийцэж байна (Зураг 19-20).

Морины тоног хэрэгсэл. Адуу малын тоног




Зураг 7.



Зураг 8.



Зураг 9.



Зураг 10.

хэрэгсэл бол бүх цаг үеийн нүүдэлчдийн хамгийн чухал зүйл билээ. Энэхүү зургийн сурвалжид өгүүлж байгаагаар, монголчууд хөлөг онгоцондоо морио ачиж далай гэтэлж ирээд морьтойгоо Японд буусан ажээ. Зурагт дүрсэлсэн Юаний цэргийн эмээл нь үнэхээр самурай нарынхаас өөр дугуй бүүрэгтэй, хойд ганзагандаа хоёр урт сур унжуулсан, хөмөлд рөгө хударгатай, дөрвөлжин гөлөмтэй, ялангуяа дөрөө нь Япончуудынхаас шал өөр, хавирган тавагтай, босоо дөрвөлжин сэнжтэй, монгол дөрөө харагдах ажээ (Зураг 3, 18, 22).

Хөгжмийн зэмсэг, туг хиур. Монголчууд баяр цэнгэлээс гадна бас дайн тулааны үед ч хөгжимдөн дуулдаг, үлээвэр хөгжмөөр цэргийн жагсаалаа тэгшитгэж, цохиур хөгжмөөр довтолгоонд уухайлан орж байсныг сурвалжид нэг бус удаа тэмдэглэсэн байдаг. Марко Поло бичихдээ: “Монголчуудад нэгэн сонин заншил буй. Тэд дайтан тулалдахаар ирж байрлаад өөрсдийн захирах тэргүүлэгчийн байлдааны их хэнгэрэг дуугарахаас нааш тулалдаанд ордоггүй бөгөөд тэд энэ зуур бүгд хөгжимдөн дуулцгаадаг аж. Ийнхүү хоёр этгээд удтал дуу дуулан наргин цэнгэлдэнэ. Монголчууд тэдний толгойлогчид “нагар” хэмээх хэнгэрэг дэлдээгүй цагт тулалдаанд үл орно. Хэнгэрэг дөнгөж дэлдмэгц тулалдаанд дайран ордог. Монгол хүмүүс тулалдаанд орохын өмнө хэнгэрэг дэлдэхийг хүлээж байхдаа дуу дуулан хоёр чавхдаст хөгжмөө намуухан татаж, хөгжилдөн тулалдааныг хүлээдэг заншилтай билээ. Хоёр этгээд заншил ёсоор тулалдаанд орохоор хэнгэргийн дэлдээн хүлээж байхдаа дуулан хөгжилдөх нь үнэхээр гайхалтай сайхан билээ” (Марко Поло 1987: 87-88, 244) гэжээ (Зураг 22).


“Монголын довтолгооны хуйлмал бичгийн” зургууд дотор, урт иштэй жаданд өлгөсөн туг хиур нэлээд дүрсэлсэн харагдах ба тэргүүн эгнээнд наран эсвэл сарны дүрстэй улаан туг өргөсөн үзэгдэнэ (Зураг 9-10, 29). Юань улсын цэрэг халдан довтолсон тухай тухайн үеийн Япон сурвалжид: “... тэргүүнд яваа онгоц улаан туг өргөхөд бүрээ дуугарч түүнтэй

зэрэгцэн цан, бөмбөр нижигнэн цуурайтах дуунаар газар тэнгэр доргин, манай цэрэг алмайрч, морьд цовхчин эмх замбараагаа алдав”, “... Юань улсын цэрэг бөмбөр, цан дэлдэж уухайлдаг учир морь цовхчин, давшиж, ухрахад хэцүү. Энэ үеэр олноор тойрон бүчиж байлдаг. Тэдний цэрэг бөмбөрийн дохиогоор нэгэн зэрэг байлдахдаа гарамгай, хэдэн зуун хүн, нум сумаар мөндөр мэт харвадаг, сумны зэв нь хортой, өртсөн хүн, морь дорхноо үхдэг. Бөөнөөрөө байлдаж сураагүй бидэнд хэцүү байлаа. Бөөрөнхий төмөр саванд дарь чихэж, түүнийгээ оньсон харвагчаар эсвэл гараараа шиддэг шинэ зэвсэгтэй. Тэр нь дэлбэрэхэд их дуу гарч, гал үсчихэд, цэргүүд цөсөө хагартал айж, нүд харанхуйлан, чих дөжирч бараг байлдаж чаддаггүй” гэх зэргээр өгүүлжээ (Мөнхцэцэг 2015b: 138-139).

Монгол хүний дүр төрх. 1246 онд Монголд ирсэн итали жуулчин Плано Карпини тэр үеийн монгол хүний дүр төрхийн талаар бичихдээ: “Нүүрний нь хэв маяг бусад хүмүүсээс ялгаатай. Тодруулж хэлбэл, хоёр нүд нь хоорондоо зай ихтэй, шанаагаараа өргөн, хацар нь гүрийсэн булчинтай, намхан хавтгай хамартай, сормууснаас хөмсгөө хүртэл бүлцэн, онигор нүдтэй, хааяа нэг дайралдах зарим хүнийг эс тооцвол ерөнхийдөө бэлхүүсээрээ нарийн, бараг цөмөөрөө дунд зэргийн нуруутай. Сахал үс гэх юм бараг



Зураг 11.



Зураг 12.

байхгүй боловч зарим нэг нь армаг тармагдуу, живэр, ооч сахалтай бөгөөд сахлаа хусна гэж байхгүй” (Plano Carpini 1997: 43) гэж тодорхойлжээ.

Хубилай хааны живсэн хөлөг онгоцуудыг эрж хайх судалгааны ажил Японд 1980-аад оноос эхэлсэн бөгөөд энэ хүртэлх хугацаанд үнэ цэнтэй олон зуун олдвор олж амжилтанд хүрсэн байна. Зарим хүний яриагаар, эдгээр болон өөр бусад олдворуудыг судлахад Хубилай хааны аян дайнд оролцогчдын ердөө нэг хувь нь л монголчууд, үлдсэн нь хятад, солонгосчууд байсан нь тогтоогдсон гэнэ. Энэ бол тодорхой баримт үгүй, одоогоор дөнгөж судалж эхэлж буй сэдэв юм. Үүнийг бичгийн сурвалжид заасан мэдээ баримттай нягталж үзэх нь зүйтэй бөгөөд монголчууд энэ дайнд чухам ямар байр суурьтай оролцсон нь нэн сонирхолтой юм.

“Монголын довтолгооны хуйлмал бичиг” зурагт дүрсэлсэн Хубилай хааны флотын цэргүүдийг дүр төрхөөр нь угсаатны онцлогоор оноож тодорхойлох бараг боломжгүй ч зарим нэг ажиглалт хийж болох мэт байна. Зургийг сайн харвал Юаний цэргүүдийн гадаад төрх, хувцас хэрэглэл, байрлал болон тугны хувьд ч ялгамжтай байгаа нь тодорхой ажиглагдана. Тухайлбал, энд хамгийн тэргүүн шугаманд япон цэрэгтэй тулаанд орж буй цэргүүд бүгд өвч хуяг, дуулгатай байхад дараагийн онгоц (эгнээнд)-нд суугаа цэргүүд нь бас өөр төрлийн хуяг, дуулга болон зэвсэгтэй байна. Гэтэл хамгийн арын онгоцонд хуяг дуулга өмсөөгүй, ямар нэгэн зэвсэг бариагүй хүмүүс үзэгдэнэ.

Хөлөг онгоцон дээрээ байгаа Юаний флотынхны дүр төрхийг ажиглавал ерөнхийдөө гурван янз буй. Үүнд: 1) Хуяг дуулга өмсөж зэр зэвсгээ агссан дайчид; 2) Хуяг дуулгагүй, хөнгөн нимгэн хувцастай сэлүүрчид (сурвалжийн мэдээ болон бусад байдлаар бодож үзэхэд эдний дунд монгол хүн байх боломжгүй); 3) хөлөг онгоцон дээр дуулгаа тайлсан, толгой нүцгэн хүмүүс байгаагийн зарим нь чихний араар гээгээ багцлан унжуулсан шибилгэр гээгтэй монгол хүн болох нь танигдаж байна. Энэ хүмүүс

тооны хувьд цөөн, хуяг дуулгатай цэргүүдийн дунд хүрээлүүлсэн байдалтай, гартаа зарим нь жад, нэг хүн илд атгажээ. Тайван ихэмсэг байдалтай, толгойгоо өргөн алсын бараа ширтсэн мэт бөгөөд цэргүүдээр хүрээлүүлсэн нь удирдах албан тушаалтай этгээд болохыг илэрхийлж байж болох юм (Зураг 24-27). Гэтэл толгой нүцгэн хүмүүсийн гээг бүгд адилгүй. Жишээ нь, хөлөг онгоцон дээр довтолгоонд өртөн амиа алдаж буй хүмүүс, сэлүүрчдийн үсний засалт дээр дурсан монгол хүмүүсийнхээс огт өөр байна (Зураг 29). Ялангуяа завин дээр бөмбөр нүдэж буй толгой нүцгэн эр хятад маягаар үсээ толгой дээрээ овоолсон харагдана (Зураг 28).

Гээг үсний засал бол аливаа ард түмний биеийн гоёл зүүсгэлийн маш чухал элемент юм. Гээг үсний тодорхой хэв маяг нь зөвхөн түүх-этнографийн ач холбогдолтой төдийгүй бас улс төрийн гүн гүнзгий учир агуулгатай байж дорно дахины ард түмний дунд тухайн хүний төрж өссөн овог аймаг, төр гүрний нь харьяаллыг тодорхойлж байсан билээ. Дундад зууны монголчуудын хувьд ч гэсэн эрэгтэй хүний гээг үс тэдний байгуулсан Дэлхийн эзэнт гүрний төр ёсных нь нэгэн чухал бэлгэ тэмдэг болж байсны олон жишээг бид мэднэ. Тиймээс ч тухайн үед Монгол газар ирсэн өрнө, дорны элчин жуулчин нар монголчуудын гээг үсний онцгой байдлыг тодорхойлон бичих гэж багагүй хичээл зүтгэл гаргаж байсанд гайхах явдалгүй юм. Дундад зууны монголчууд үс гээгээ ямар байдлаар засч янзалдаг байсныг магадлан үзэхэд зулай дээрээ гөхөл хэмээх хэсэг үс үлдээж тойруулан хусаад шанаа болон ар дагзны үсийг хэвээр орхин үүнээсээ шибилгэр хэмээх хоёр салаа гээг гөрж, тус бүрийг чихний араар багцлан боож унжуулдаг байсан ажээ. Бичгийн түүхийн сурвалжид, XIII-XIV зууны монголчууд хаан эзнээсээ эхлээд харц ардаа хүртэл үс гээгээ гагцхүү дээр өгүүлсэн маяг хэлбэрээр засч янзалдаг байсан төдийгүй, эзлэн дагуулсан орны хүмүүст ч дагаж орсны тэмдэг болгон ийм гээг тавиулж байсныг тэмдэглэжээ (Баяр, Эрдэнэбат 2011:

515-527).

Энэ бүхнээс үзэхэд, 13 дугаар зууны сүүл үед бүтээгдсэн “Монголын довтолгооны хуйлмал бичиг” (Moko Shurai Ekotoba) хэмээх зурагт ном нь тухайн үеийн хүмүүсийн дүр төрх, ахуй байдал, түүхэн үйл явдлыг бодит байдалд ойрхон дүрсэлсэн, урлагийн төдийгүй түүхийн судалгааны ач холбогдолтой, тухайн цаг үеийн итгэмжит нэгэн эх сурвалж болох нь нотлогдож байна. Нэмж дурдахад эдгээр нь ялангуяа монголчуудын тухай, тэдний түүхийн талаар маш олон нийтлэл гарч байгаа өнөө үед соёлын түүхийн ихээхэн сонирхол татаж байна. Энэ сэдвээр цаашид үргэлжлүүлэн судлахад сонирхолтой үр дүн гарна хэмээн найдаж байна.

Abstract

Observations on the depiction of mongols in the “Pictorial account of the Mongol invasions” (蒙古襲来絵詞 Moko Shurai Ekotoba)

Ulbayyar Erdenebat

During the reign of the Great Mongol Khan Khubilai, the Yuan dynasty launched two invasions against Japan in 1274 and 1281. Among the notable records in Japan related to the Yuan invasions, the “Pictorial Account of the Mongol Invasions” (蒙古襲来絵詞 Moko Shurai Ekotoba) stands out as an important historical and artistic source. The main protagonist of this work, Takezaki Suenaga, was a samurai from Higo Province on the island of Kyushu. He personally participated in the two battles against the Mongols during the 13th century Kamakura period. It is said that he commissioned this scroll to depict his achievements and heroic deeds during the war. The “Pictorial Account of the Mongol Invasions” is a highly valuable resource for studying the appearance of Yuan and Japanese soldiers, their clothing, weapons, warhorses’ equipment, the structure of ships, combat techniques, and military strategies. This article shares observations and findings regarding the depiction of Mongols within this illustrated source.

Keywords: Mongol Empire, Yuan Dynasty, Khubilai Khan, Mongol Invasions to Japan, Mōko Shūrai Ekotoba

Ном зүй

Баяр, Д., Эрдэнэбат, У. (2015). Дундад эртний монголчуудын гээг үс. “Антоон Мостаэрт ба Монгол судлал”. УБ: 515-527.

Дружинина, И.А. (2018). Шлем. “Золотая Орда и Причерноморье. Уроки Чингисидской Империи”. Каталог

выставки. Фонд Марджани. М: 110-112.

Марко Поло (1987). Орчлонгийн элдэв сонин (Аяны тэмдэглэл). УБ.

Мөнхцэцэг, Т. (2015a). Хубилай хаан ба Япон. “Хубилай хаан ба түүнийг залгамжлагчид”. УБ: 100-115.

Мөнхцэцэг Т. (2015b). Хубилай хааны Япон улсын талаар хэрэгжүүлсэн бодлогын тухайд. “Хубилай сэцэн хаан ба Монголын Юань улс”. УБ: 138.

Плано Карпини (1988). Монголчуудын түүх. УБ.

Эрдэнэбат, У. (2012). Археологийн үндэс Судалгааны аргазүй (Сурах бичиг). УБ.

Эрдэнэбат, У. (2014). Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Дунд нурууны хадны оршуулгын дурсгалууд. *Studia Archaeologica*. Tom. XXXIV, Fasc. 28: 344-365.

Эрдэнэбат, У., Амартүвшин, Ч. (2010). Дугуй Цахирын хадны оршуулга. УБ.


Conlan, T. (2001). In Little Need of Divine Intervention. Takezaki Suenaga’s Scrolls of the Mongol Invasion of Japan. Translation with Interpretive Essay Thomas D. Conlan. East Asia Program, Cornell University, Ithaca, New York.

Fischer-Wieruszowski, Frieda (1935). Kriegerischer Einfall der Mongolen in Japan. Eine japanische Bildrolle. In: *Ostasiatische Zeitschrift*. Neue Folge 11. Jahrgang, der ganzen Reihe 21. Jahrgang. Berlin und Leipzig, Verlag von Walter de Gruyter & Co, 121-124.

Plano Carpini (1997). Kunde von den Mongolen 1245-1247. Uebersetzt, eingeleitet und erläutert von Felicitas Schmieder. Jan Thorbecke Verlag Sigmaringen.

Received: Oct. 6, 2024; Revised: Nov. 10, 2024; Accepted: Dec. 16, 2024





Зураг 13.



Зураг 14.



Зураг 15.



Зургаг 16.



Зургаг 17.




Зургаг 18.



Зургаг 19.



Зургаг 20.





Зургаг 21.



Зураг 22.




Зураг 23.




Зураг 24.




Зураг 25.




Зургаг 26.



Зургаг 27.



Зургаг 28.



Зургаг 29.